

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Огноо: 2019.08.28

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛЬД ҮДИЙН ЦАЙ НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫГ ХУДАЛДАН АВАХ**

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр:

Төслийн дугаар:

Тендер шалгаруулалт/гэрээний нэр: Ерөнхий боловсролын сургуульд үдийн цай нийлүүлэх ажил

Тендер шалгаруулалт/гэрээний дугаар: УТ-ХА-06/2020.....

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

___2020.08.28___

Дорноговь аймаг Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Ерөнхий боловсролын сургуульд үдийн цай нийлүүлэх** ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 10:00 цаг**-аас өмнө **Дорноговь аймаг Эрдэнэ сум 5-р баг Засаг даргын Тамгын газарт** гэсэн хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020.09.07-ний өдрийн 10:30¹**-т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорноговь аймаг Эрдэнэ сум Засаг даргын Тамгын газар
Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Б.Буянтогтох 96001452

¹ Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**хүчинтэй
байх
хугацаа**

**6. Алдааг
залруулах**

6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

**7. Санал
болгосон
үнэ,
түүнийг
үнэлэх**

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах
эрх олгох
тухай
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ. Үүнд :</p> <p>Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн Үдийн цай хөтөлбөрт Мах болон цагаан хоол / уух зүйл дагалдана/, Гурилан бүтээгдэхүүн / уух зүйл дагалдана/, Сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх</p> <p>Тендер шалгаруулалтад оролцогч нь дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд :</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/; 2. Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл / гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн ажил / 3. Аж ахуй нэгж байгууллагыны хувьд Улсын бүртгэлийн гэрчилгээ, хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ. 4. Тухайн бараа ажил үйлчилгээ нийлүүлэхэд хүнсний үйлдвэрлэл үйлчилгээ явуулах зөвшөөрөлтэй, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлтийн эх хувиас татсан хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ. 5. Мэргэжлийн хяналтын газраас ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байх тухайн баримтын хуулбар 6. Тоног төхөөрөмжийн хүчин чадлыг тооцож хоногт гарах бүтээгдэхүүний тоо, тоног төхөөрөмжүүдийн жагсаалтыг зургийн хамт ирүүлэх / Техник ашиглалтын карт, фото зураг / 7. Нэгж бүтээгдэхүүний үндсэн шимт бодис тооцсон мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт 8. Технологийн карт ирүүлэх 9. Оролцогч компанийн танилцуулга 10. Татварын газрын тодорхойлолт / өргүй байх / Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх 11. Монгол банкны тодорхойлолт / хугацаа хэтэрсэн өр, зээлийн үлдэгдэлгүй байх / 12. Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт / өргүй байх / Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх 13. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх <p>Сүүлийн 3 жилд ял шийтгэлтэй, одоо өр төлбөртэй байсан нь холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тодорхойлолтоор нотлогдсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <ol style="list-style-type: none"> 14. Тухайн барааг нийлүүлэхэд шаардлагатай мэргэжилтэй ажилчдын мэргэжлийн бэлтгэл, туршлагыг дараах

хүснэгтээр ирүүлнэ. Үүнд :

Албан тушаал	Мэргэжил	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн тоо
Тогооч	Тогооч	1	3-аас доошгүй жил
Хоол түгээгч	Мэргэжил харгалзахгүй	1	Харгалзахгүй

Дээрх хүснэгтэд заасан мэргэжилтэй ажилчдын иргэний үнэмлэх, мэргэжлийн үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд орсныг нотлох дэвтэр баримт бичгийг эх хувиас татсан хуулбарыг ирүүлнэ.

Дээрх нэмэлт материалуудаас нэг буюу хэд хэдэн баримт бичиг, нотлох баримт ирүүлээгүй эсвэл шаардлага хангаагүй, баталгаажуулаагүй ба зөрчил бүхий хуурамч нотлох баримтууд ирүүлсэн, сүүлийн 2 жилд нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний чанар хангалтгүй байсан нь өмнөх захиалагч байгууллагуудын тодорхойлолтоор болон хяналт шалгалтын байгууллагын дүгнэлтээр нотлогдсон зэрэг тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.

15. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо : 2 жил

Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээллийг дараах хүснэгтээр ирүүлнэ.

№	Гэрээн ий нэр	Бараа / ажил/-ын нэр нэр	Гэрээний үнийн дүн /мян.төг/	Захиалагчийн мэдээлэл		
				Нэр	Хаяг	Утасны дугаар

Дээрх мэдээллийн хамт өмнөх захиалагч сүүлийн 2 жилд байгуулсан гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт, гэрээний хэрэгжилтийн үр дүнгийн талаар өмнөх бүх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.

16. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд / өөрийн, түрээслэх, хөлслөх гэх мэт/ бэлэн байлгах шаардлагтай. Үүнд :

Машин тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр зориулалт	Тоо хэмжээ	Бүртгэлийн гэрчилгээ, техникийн паспорт дугаар	Эзэмшдэг байгууллага, иргэний нэр	Чанар байдал ашиглалт ад орсон огноо
Цайны зориулалтын халуун сав				
Гадна орчны хорт болон халуун хүйтний нөлөөллөөс хамгаалах зориулалтын				

сав баглаа				
Хоолны дээжний хөргөгч				
Хоолны халуун сав				

Үдийн цай хөтөлбөрт хүсний бүтээгдэхүүн нийлүүлэх шалгуур үзүүлэлт :

Хүнсний үйлдвэрлэл явуулах зөвшөөрөлтэй, Улсын мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй байх.

Нийлүүлэхээр санал болгож буй бүтээгдэхүүнийг эрүүл ахуй, аюулгүй байдлын шинжилгээнд бүрэн хамруулсан байх.

Бүтээгдэхүүнээ цайны цагаас 5 минутын өмнө сургууль дээр авчирсан байх.

Гэрээний хэрэгжилтээр санхүүгийн хариуцлага хүлээх чадвартай байх.

Цэцэрлэг, сургуулийн хүүхдэд зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн хүлээн авах, хадгалах, тээвэрлэхэд Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2010 оны 8 дугаар сарын 27-ний өдрийн 206 дугаар тушаалаар батлагдсан “Хоолны газрын нийтлэг журам”-ын 4 дүгээр зүйлд заасан шаардлагыг баримтлана. Үүнд :

1.Хоолны газар нь үйлдвэрлэл, үйлчилгээний технологи, хөдөлмөр хамгаалал, техникийн болон галын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ариун цэврийн үндсэн шаардлагыг хангасан байна.

2.Хоолны газрын агаар сэлгэлтийн системийг гал тогоонд ялгаруулж буй хоолны үнэр, утаа, уурыг үйлчилгээний танхимд тархахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, бусад өрөө, тасалгааны талбайн хэмжээ онцлогоос хамаарч агаар сэлгэлтийн системийн хүчин чадлыг тооцож суурилуулсан байна.

3.Хоолны газарт суурилуулсан агаар сэлгэлтийн системийн дуу нь 67 децибаллаас дээшгүй байна.

4. Хоол үйлдвэрлэлийн өрөөний шал, хана, таазыг ус нэвтэрдэггүй, бат бөх, тэгш гөлгөр гадаргуутай, өнгө үзэмж сайтай цэвэрлэхэд хялбар засаж сэлбэх боломжтой материалаар хийж, хортон шавьж, бичил биетэн үржихээс хамгаалсан байна.

5.Хоолны газар нь хэрэглэгчид зориулсан гар угаах, хатаах төхөөрөмж бүхий бие засах газар, хувцасны өлгүүр, гутал арчигч зэргийг байрлуулсан байна.

6.Хоолны газар нь ажилтны амралтын болон хувцас солих өрөө, гадуур хувцас, цүнх зэрэг хувийн эд зүйлсийг хадгалах зориулалтын шүүгээтэй байна.

7.Хоолны газарт гал түймэр унтраах хэрэгслүүдийг байрлуулсан байна.

8.Техник, тоног төхөөрөмж нь цахилгааны болон галын

	<p>аюулгүйн техник ашиглалтын дүрмийн шаардлагыг бүрэн хангасан байна.</p> <p>9.Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны газар нь бэлэн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг гадны бохирдолоос хамгаалсан хатуу хучилттай талбай дээр байрлуулж, хог хаягдлын цэгээс 100 метрээс багагүй зайтай байна</p> <p>10.Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны газар нь хагас боловсруулсан болон бэлэн халуун, хүйтэн хоол, бүтээгдэхүүн хадгалах зориулалтын хоол халуун байлгагч, хөргөх төхөөрөмжөөр хангагдсан, нэг хэрэглээний сав, хэрэгсэл хадгалах зориулалтын шүүгээтэй байна.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дорноговь аймгийн Эрдэнэ сум 5-р баг Засаг даргын Тамгын газар</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Нэг цэгийн үйлчилгээний заал Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Буянтогтох 96001452, 95601452</p> <p>Огноо: 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дорноговь аймгийн Эрдэнэ сум 5-р баг Засаг даргын Тамгын газар</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Өрөө №06 Засаг даргын орлогчийн албан өрөө</p> <p>Огноо: 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуульд үдийн цай нийлүүлэх 1 багцтай.</p>
	<p>Санхүүгийн эх үүсвэр : 2020 оны Улсын төсвийн санхүүжилтаар хийнэ.</p> <p>Жич : Өөрийн хөрөнгөөр ажлыг гүйцэтгэж холбогдох байгууллагад хүлээлгэн өгснөөр тухай бүрт санхүүжилтийг олгоно.</p>
	<p>Борлуулалтын хэмжээ : Жилийн борлуулалтын орлого 15,0 сая төгрөг</p>
	<p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжит зээлийн хэмжээ : 10,0 сая төгрөг</p>

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Багц	Бүтээгдэхүүн	Бүтээгдэхүүний тодорхойлолт
Үдийн цай	Махан болон цагаан хоол / уух зүйл дагалдах /	-Долоогоос дээш нэр төрлийн бүтээгдэхүүн санал болгох -Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан байх. -Шаардлагын дагуу савлах, зөөж тээвэрлэх боломжтой байх. -Хүнсний шинэ бүтээгдэхүүнээр үйлчлэх, хадгалалтын хэвийн баримтлах нөхцөлийг бүрдүүлсэн байх. -Бусад шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх -Хоол болон нарийн боовны үнэ 400 төгрөгт, шингэн зүйлийн үнэ 200 төгрөгт багтсан байх.
	Гурилан бүтээгдэхүүн / уух зүйл дагалдах /	Гарал үүслийн бичигтэй. Нян судлалын шинжилгээтэй.
	Ариутгасан сүү	
	Тараг	
	Аарц	
	Ааруул	
	Цагаа / буцалгаа /	
	Жимс, жимсгэнэ	
	Бусад хүнсний бүтээгдэхүүн	

Тав. АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

№	Багцын нэр	Долоо хоногт хэдэн удаа авах	Нийт хэдэн долоо хоног авах	Үдийн цайнд хамрагдах сурагчдын тоо
1	<i>Багц-1 : Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн Үдийн цай хөтөлбөрт Мах болон цагаан хоол / уух зүйл дагалдана/ нийлүүлэх</i>	2	32	168
	<i>Гурилан бүтээгдэхүүн / уух зүйл дагалдана/ нийлүүлэх</i>	2	32	168

	<i>Сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх</i>	1	32	168
--	---	---	----	-----

Долоо.ЖИШИГ МАЯГТ
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх** 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
2. **Төслийн менежерийн шийдвэр** 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
3. **Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх** 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
4. **Аюулгүй байдал** 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5. **Зааварчилгаа** 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. **Маргааныг шийдвэрлэх** 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
7. **Ажлын хөтөлбөр** **Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**
7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. **Зөрчил, гологдол илрүүлэх** 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

9. Зөрчил, гологдол арилгах

9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа² дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.

10. Зөрчил, гологдол арилгахгүй байх

10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. Үе шатны ажлын хуваарь

11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.

11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.

12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх

12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.

13. Алданги

13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги³ төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

14. Ажил

14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах

² Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

³ Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

дуусгах	хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
15.Хүлээж авах	15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16.Эцсийн тооцоо	16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
17.Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага	17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө. 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
18.Гэрээг цуцлах	18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй. 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй: (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

- (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

20. Гүйцэтгэлэ эс чөлөөлөх

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ⁴

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн Үдийн цай нийлүүлэх УТ-ХА-06/2020
ГЕН 2.1	Ажил нь Багц-1 : Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн Үдийн цай хөтөлбөрт Мах болон цагаан хоол / уух зүйл дагалдана/, Гурилан бүтээгдэхүүн / уух зүйл дагалдана/, Сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх Ажлын талбай нь Дорноговь аймаг Эрдэнэ сум 5-р баг Ерөнхий боловсролын сургууль, хичээлийн байр -д байрших захиалагчийн зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь ЗДТГазрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Өлзиймөнгө
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр : 2020.09.01 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр : 2020.06.10⁵
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа [90] хоног байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [0,1 хувь] байна. ⁶ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [10 хувь] байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг ажлыг бүрэн дуусгаад комисст хүлээлгэн өгөхдөө хамт ажлын 3 хоног -ийн дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг ажлыг бүрэн дуусгаад комисст хүлээлгэн өгөхдөө хамт ажлын 3 хоног -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [0] байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [0 хувь] -иартооцно.

⁴ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁵ Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

⁶ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/
Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай/ _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах

барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж,
_____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]